

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

*Орон нутгийн 2023 оны нөхөн болон дахин сонгууль зохион
байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл"-д
хийсэн аудитын тайлан*

АУДИТЫН КОД: ДОА-2023/53-7-ШТА-ГА

Чойбалсан хот 2023 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батжаргал
Утас: 7058-4207, Цахим хаяг: Batjargalb@audit.gov.mn
Аудитор М.Ухаанбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn
Аудитор М.Ганбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: Ganbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.open.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Дүрслэлийн товъёог	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	3
Ерөнхий мэдээлэл	4
БҮЛЭГ 1. ДОРНОД АЙМГИЙН ЧОЙБАЛСАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ СЕХ-НООС ИРҮҮЛСЭН АРГАЧЛАЛ, ЗӨВЛӨМЖ, ЧИГЛЭЛИЙН ДАГУУ ХУВААРИЛСАН БАЙНА.....	5-6
БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛСАН ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.....	7-8
БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛСАН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭН ЗӨВ ТАЙЛАГНАСАН БАЙНА.....	8-9
ДҮГНЭЛТ:	9
ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН ХАРИУ ТАЙЛБАР:	10
ЗӨВЛӨМЖ:	11
АЛБАН ШААРДЛАГА.....	12
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ	13

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ДОА	Дорнод аймаг
ГА	Гүйцэтгэлийн аудит
ШТА	Шууд тайлагналын аудит
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ҮАГ	Үндэсний аудитын газар
МТБ	Мэдээлэл технологийн баг

ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁОГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Батлагдсан төсөв эдийн засгийн ангиллаар.	6
Дүрслэл 2	Зардлын гүйцэтгэл аймаг, сумдаар.	7
Хүснэгт 1	Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл.	8

	АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, 29 дүгээр зүйлийн 29.1.10 дахь заалт, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8, 10.11-т заасныг үндэслэн хийлээ.
Аудитын зорилт	Чойбалсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Энэхүү зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • Чойбалсан сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх; • Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэх • Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнасан эсэх
Аудитын хамарсан хүрээ	Дорнод аймгийн Сонгуулийн хороо нь Чойбалсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн мэдээ, аймгийн болон Чойбалсан сумын сонгуулийн хорооны санхүүгийн баримтыг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	АДБОУС 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Гүйцэтгэлийн аудит MNS 6817-7:2020, Гүйцэтгэлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимуудыг ашиглав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батжаргал, аудитор М.Ухаанбилэг, М.Ганбилэг нар хийж гүйцэтгэлээ. Аудитын талбарын ажлыг 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс эхлүүлж, тайланг ЯАГ-ын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газар болон аймгийн Сонгуулийн хороонд 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр хүргүүлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Дорнод аймгийн Чойбалсан сумд зохион байгуулагдах орон нутгийн хурлын 2023 оны нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах сонгуулийн хорооны бүрэлдэхүүнийг Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2023 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 16/13 дугаар тогтоолоор аймгийн Сонгуулийн хороог Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, 5 гишүүдтэй нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

Дорнод аймгийн Чойбалсан сумын 2023 оны нөхөн сонгуулийг 2 хэсгийн хороодтой зохион байгуулж, тэдгээрт ажиллах 23 төрийн албан хаагч ажилтан томилогдон ажилласан байна.

Чойбалсан сумын нөхөн сонгуульд санал өгөх сонгогчийн нэрийн жагсаалтад 969 сонгогч бүртгэлтэй байгаагаас санал хураалтад нийт 172 сонгогч буюу иргэдийн 17.8 хувь нь саналаа өгсөн байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос Дорнод аймгийн Сонгуулийн хороонд 1166 ширхэг саналын хуудас олгосноос 172 ширхэг буюу 14.7 хувь нь санал хураалтад зарцуулагдаж, 994 ширхэг саналын хуудас зарцуулагдаагүй үлдсэн байна.

Дорнод аймгийн Чойбалсан сумын 2023 оны нөхөн сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Сонгуулийн ерөнхий хорооноос аймгийн Сонгуулийн хороонд 34.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аймгийн сонгуулийн хороонд 17.3 сая төгрөг, Чойбалсан сумын сонгуулийн хороонд 17.0 сая төгрөг, нийт 34.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Бүлэг 1. Дорнод аймгийн Чойбалсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг СЕХ-ноос ирүүлсэн аргачлал, зөвлөмж, чиглэлийн дагуу хуваарилсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны даргын 2023 оны А/19 дугаартай тушаалаар Дорнод аймгийн Чойбалсан сумын 2023 оны нөхөн сонгуулийг зохион байгуулах аймгийн Сонгуулийн хорооны төсвийг 34.3 сая төгрөгөөр баталсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос дээрх төсвийг аймгийн Сонгуулийн хороонд бүрэн хуваарилсан байна.

Дорнод аймгийн Сонгуулийн хороо нь Чойбалсан сумын 2023 оны нөхөн сонгуулийг зохион байгуулах сумын Сонгуулийн хорооны санхүүжилтийг олгохдоо Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны 2023 оны 3/172, 3/217, 3/236, 3/240 тоот албан бичгээр ирүүлсэн зарцуулалтын тайлбар, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2022 оны А/17 дугаар захирамжийн дагуу төсвийг зардал тус бүрээр суманд хуваарилан олгосон байна.

Дүрслэл 1. Батлагдсан төсөв эдийн засгийн ангиллаар.



Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл.

Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан 34.3 сая төгрөгөөс аймгийн Сонгуулийн хороо нь Чойбалсан сумын Сонгуулийн хороонд 17.0 сая төгрөгийг хуваарилсан байна.

Нийт төсвийг дараах байдлаар зарцуулжээ. Үүнд: Урамшуулал, хоолны зардалд 15.6 сая төгрөг буюу 45.4 хувийг, саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардалд 5.8 сая төгрөг буюу 16.9 хувийг, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардалд 2.4 сая төгрөг буюу 7.0 хувийг, томилолтын зардалд 2.2 сая төгрөг буюу 6.5 хувийг, аймаг, нийслэл, сум дүүргийн, хэсгийн хорооны унааны зардалд 2.1 сая төгрөг буюу 5.9 хувийг, саналын хуудас устгах зардалд 1.6 сая төгрөг буюу 4.7 хувийг, үлдэх 3.6 сая төгрөг буюу 10.6 хувийг бусад зардлуудад зарцуулж, болзошгүй зардал болох 1.0 сая төгрөгийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлжээ.


Бүлэг 2. Орон нутгийн хурлын нөхөн сонгууль зохион байгуулсан зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Дорнод аймгийн Чойбалсан сумын 2023 оны нөхөн сонгуулийн зардалд улсын төсвөөс хуваарилсан 34.3 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч зарцуулсан байна.

Дорнод Аймгийн Сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч цахим төлбөрийн мэдэгдэл гаргаж нэг удаагийн нууц дугаарууд ашиглан цахимаар гүйлгээг хийж ажилласан байна.

Харин Чойбалсан сумын Сонгуулийн хорооны дарга сонгуулийн хорооны зардлын нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч хоёрдугаар гарын үсгийг зурж ажилласан байна.

Дүрслэл 2. Зардлын гүйцэтгэл аймаг, сумаар. /сая.төгрөгөөр/



Аймгийн сонгуулийн хороо 16.3 сая төгрөг, Чойбалсан сумын сонгуулийн хороо 17.0 сая төгрөг, нийт 33.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс аймгийн Сонгуулийн хороо болзошгүй зардалд тавигдсан 1.0 сая төгрөгийг СЕХ-ны дансанд буцаан төвлөрүүлжээ.

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл.

Сонгуулийн хороодын зардлын зарцуулалтыг төсвийн гүйцэтгэлийн мэдээ, дансны хуулга, анхан шатны баримтуудтай тулган шалгасан.

Чойбалсан сумын Сонгуулийн хороо нь нөхөн сонгуулийг зохион байгуулах салбар хороо, хэсгийн хороодод ажилласан 23 албан хаагчдад олгосон 13.8 сая төгрөгийн

урамшуулал, хоолны мөнгөн дүнгээс хувь хүний орлогын албан татварын нэхэмжлэл үүсгээгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн “6.3.Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно.” “6.3.1.цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;” гэж заасантай нийцэхгүй байна.

Дорнод аймгийн Сонгуулийн хороо нь 1.6 сая төгрөгөөр саналын хуудас устгуулсан нь холбогдох дэмжих баримтаар нотлогдохгүй байна.

Хүснэгт 1: Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төлөвлөгөө	Аймгийн сонгуулийн хорооны гүйцэтгэл	Чойбалсан сумын хэсгийн хороо
1	Маягт үнэмлэх хэвлүүлэх зардал	130,000	80,000	50,000
2	Үнэмлэх хэвлэх	70,000	70,000	-
3	Сонгуулийн хорооны сургалтын зардал	310,000	310,000	-
4	МТБ-ийн даамлын сургалтын зардал	40,000	40,000	-
5	Аймаг, нийслэл, сум дүүргийн, хэсгийн хорооны бичиг хэргийн зардал	650,000	300,000	350,000
6	Аймаг, нийслэл, сум дүүргийн, хэсгийн хорооны шуудан холбооны зардал	750,000	300,000	450,000
7	Аймаг, нийслэл, сум дүүргийн, хэсгийн хорооны унааны зардал	2,030,000	2,030,000	-
8	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	600,000	-	600,000
9	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардал	5,818,000	4,886,400	931,600
10	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	170,000	170,000	-
11	Мэдээ дамжуулах унааны зардал	210,000	-	210,000
12	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	240,000	-	240,000
13	Сурталчилгааны зардал	500,000	-	500,000
14	Томилолтын зардал	2,222,000	1,682,000	540,000
15	Болзошгүй зардал	1,000,000	-	-
16	Аймаг, нийслэл, сум, дүүргийн хэсгийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	15,600,000	4,200,000	11,400,000
17	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	2,400,000	600,000	1,800,000
18	Саналын хуудас устгах зардал	1,604,000	1,604,000	-
	Нийт	34,344,000	16,272,400	17,071,600

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл.

Бүлэг 3. Орон нутгийн хурлын нөхөн сонгууль зохион байгуулсан зардлын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнасан байна.

Дорнод аймгийн Чойбалсан сумын 2022 оны нөхөн сонгууль зохион байгуулсан зардлыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу аймгийн Сонгуулийн хороо 16.3 сая төгрөг, Чойбалсан сумын сонгуулийн хороо 17.0 сая төгрөгийн зардлын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнасан байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь Чойбалсан сумын сонгуулийн хороонд зардлын санхүүжилт, гүйцэтгэлд аргачлал, зөвлөмж, чиглэлийг тухай бүр өгч хяналтыг тавьж ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай. Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна” гэж хуульчилсан.

Аудитаар аймгийн болон Чойбалсан сумын Сонгуулийн хорооны 5.0 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг тулган үзэхэд 5.0 сая төгрөгөөс дээш 13.2 сая төгрөгийн орлогын 1 гүйлгээг байршуулж ажиллаагүй байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Дорнод аймгийн Чойбалсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг СЕХ-ноос ирүүлсэн аргачлал, зөвлөмж, чиглэлийн дагуу хуваарилсан байна.
2. Орон нутгийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулсан зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.
3. Чойбалсан сумын Сонгуулийн хороо нь сонгуульд ажилласан албан хаагч нарт олгосон урамшуулал, хоолны зардалд татварын е-баримтгүй гүйлгээ хийсэн байна.
4. Аймгийн Сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хороонд зардлын санхүүжилт, гүйцэтгэлд аргачлал, зөвлөмж, чиглэлийг тухай бүр өгч хяналтыг тавьж ажилласан байна.
5. Шилэн дансны цахим сайтад Чойбалсан сумын Сонгуулийн хороо нь 13.2 сая төгрөгийн орлогыг мэдээлээгүй байна.

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН ХАРИУ:



ДОРНОД АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО

21000, Чойбалсан, Дорнод аймаг,
Утас/ факс: 7058-4681

2023.07.07 № 05

танай _____-ны № _____-т

Г ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН Г
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ
ТАНАА

Аймаг, нийслэл, сум дүүргийн 2023 оны нөхөн
сонгуулийн аймаг, сумын сонгуулийн хорооны
зардлын тайланд хийсэн аудитын тайлантай
танилцлаа.

Албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн
ажиллана.



СОНГУУЛИЙН ХОРООНЫ
ДАРГА П.БАТ-ӨЛЗИЙ

Б.Батмунгал:

Аудитын тайланд хавсруулж,
аудитын тайланг ажлын
баталгаажуулав.

2023.07.07
[Signature]

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зөвлөмжийг өгч байна.

1. Чойбалсан сумын Сонгуулийн хороо нь сонгуульд ажилласан албан хаагч нарт олгосон урамшуулал, хоолны зардалд татварын е-баримтаар шилжүүлэг хийж байх.
2. Шилэн дансны тухай хуульд заасан 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг мэдээлж байх.

Аудитаар нийт 16.2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 1.6 сая төгрөгийн албан шаардлага, 14.6 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгч ажиллаа.

Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2023 оны 07 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

АЛБАН ШААРДЛАГА:


**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 07 сарын 07 өдөр Дугаар 224 ДОА-2023/53-7-ШТА-ГА Чойбалсан хот
1170309

Г 7

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3 дахь заалт, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8, 10.11 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны "Аудитын жилийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" А/61 дүгээр тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний 1.2 дахь хэсэгт хавсралтад дурдсан нэмэлт, өөрчлөлтийг үндэслэн "Орон нутгийн 2023 оны нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд"-д гүйцэтгэлийн аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дорнод аймгийн Сонгуулийн хороо нь саналын хуудас устгасан зардалд 1.6 сая төгрөгийг зарцуулсан нь холбогдох дэмжих баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан "Саналын хуудсыг хэвлүүлэх, хүргүүлэх, хадгалах, хамгаалах журам"-ын 5.4 -т "Хадгалах хугацаа нь дууссан саналын хуудсыг Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрээр устгах ба аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс томилсон Ажлын хэсэг устгах ажлыг зохион байгуулж, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ." гэсэн заалтыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох журмын дагуу саналын хуудас устгах ажлыг зохион байгуулах
2. Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 07 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймгийн сонгуулийн хорооны дарга П.Бат-Өлзий-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР	Б.БАТЖАРГАЛ
АУДИТОР	М.УХААНБИЛЭГ



ТУШААЛ:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/25

Чойбалсан хот

Г Тайлан баталгаажуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитаар өгөгдсөн албан шаардлагыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Дорнод аймгийн Сонгуулийн хорооны дарга П.Бат-Өлзий нарт хүргүүлсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Батжаргалд даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010057

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны
07 дугаар сарын 07-ны өдрийн
1/25 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр	Албан шаардлагын дугаар	Албан шаардлагын дүн /сая.төг/
1	Дорнод аймгийн Сонгуулийн хороо	01/224 ДОА-2023/53-7-ШТА-ГА	1.6
дүн			1.6

